



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 20

Мандалговь

Үндсэн хөрөнгөд үнэлгээ тогтоож худалдах,  
акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 7,845,335,08 (Долоон сая найман зуун дөчин таван мянга гурван зуун гучин таван төгрөг) төгрөгийн балансын үнэтэй, 5,753,245,96 (Таван сая долоон зуун тавин гурван мянга хоёр зуун дөчин таван төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй ногооны зоорийг нэгдүгээр хавсралтын дагуу акталж, данснаас хасах, 8,629,414,81 (найман сая зургаан зуун хорин есөн мянга дөрвөн зуун арван дөрвөн төгрөг наян нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 5,177,648,89 (Таван сая нэг зуун далан долоон мянга зургаан зуун дөчин найман төгрөг наян есөн мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй нүүрсний цэнхэр амбаарыг хоёрдугаар хавсралтад заасны дагуу нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ё.Сайхантуяа), Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэж, ашиглах, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.МӨНХЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн  
20 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын  
актлах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгууламж йн нэр	Зориулал т	Хүчин чадал		Ашиглалт анд орсон огноо	Ашиглал- тын нийт хугацаа /жилээр /	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдса н элэгдэл	Үлдэгдэл өртөг
			хэмжи х нэгж	биет хэмжээ						
1	Зоорь	агуулах	ш		2008.12.0 1	15	1	7,845,335,08	2,092,089,12	5,753,245,96
<b>Нийт дүн</b>								<b>7,845,335,08</b> (долоон сая найман зуун дөчин таван мянга гурван зуун гучин таван төгрөг ) төгрөг	<b>2,092,089,12</b> (хоёр сая ерэн хоёр мянга наян есөн төгрөг арван хоёр мөнгө) төгрөг	<b>5,753,245,96</b> (таван сая долоон зуун тавин гурван мянга хоёр зуун дөчин таван төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн  
20 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын  
худалдах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтанд орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жилээр /	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			ХЭМЖИХ НЭГЖ	БИЕТ ХЭМЖЭЭ							
1	Нүүрсний цэнхэр амбаар	Нүүрс агуулах	ш		2012.11.29	10	1	8,629,414,81	3,451,765,92	5,177,648,89	100,000
<b>Нийт дүн</b>								<b>8,629,414,81</b> (найман сая зургаан зуун хорин есөн мянга дөрвөн зуун арван дөрвөн төгрөг наян нэгэн мөнгө) төгрөг	<b>3,451,765,92</b> (гурван сая дөрвөн зуун тавин нэгэн мянга долоон зуун жаран таван төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөг	<b>5,177,648,89</b> (таван сая нэг зуун далан долоон мянга зургаан зуун дөчин найман төгрөг наян есөн мөнгө) төгрөг	<b>100,000</b> (нэг зуун мянга) төгрөг